

ӨГҮҮЛЭЛ

1954 оны Монгол-Хятадын ажиллах хүчний хэлэлцээрийн хүрээнд Өвөр Монголоос ажилчин авах Монголын бодлого

Намжилчойжилын Алтантөгс 

Ph.D

Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
altantugs@num.edu.mn

Хураангуй: БНМАУ-ын бүтээн байгуулалтад ажиллах хүчнээр туслах тухай БНМАУ-БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 1955-1964 онд нийт 12 мянга орчим хятад ажилчид БНМАУ-д ирж ажилласан билээ. Энэ тухай хэлэлцээрийг 1955 онд хоёр талын төлөөлөгчид боловсруулах үеэр Монголын төлөөлөгчид аль болох олон ажилчныг аль болох урт хугацаагаар, боломжтой бол БНМАУ-д амьдрах эрхтэй үлдээхээр аваачихыг эрмэлзэж байсан нь архивын баримтад тэмдэглэгдэн үлджээ. Энэ хүсэлтийн учир шалтгааныг тодруулахыг уг өгүүллээр зорив. Ингэхдээ хэлэлцээрийн агуулга, цаашидын хэрэгжилтийг Монголын ба Хятадын гадаад бодлого, үйл ажиллагаатай уялдуулан үзэв. Монголын тал Хятадаас ажиллах хүч авахдаа тэдгээр ажилчдад Монголд амьдрах эрх олгох, гэр бүлийг нь Монголд авчрах, Хятад руу мөнгө гуйвуулахгүй байлгахыг эрмэлзэж байсан явдал бол тэднийг буцаалгүй суурьшуулах, улмаар Монголын иргэн болгохыг зорьсон явдал мөн боловч хятад ажилчид 1964 онд Монголоос буцахад Монголд тэднээс бараг хүн үлдсэнгүй. 1950-иад онд явуулсан Монголын гадаад, дотоод бодлогын зарим шинж чанар, Өвөр Монголоос ажилчин ирүүлэх тухай Хятадын талд тавьсан удаа дараагийн хүсэлтүүдтэй уялдуулан үзвэл, Хятадаас ажиллах хүч ирүүлэх Монголын эрмэлзэл нь ажиллах хүчний хомсдолоо шийдвэрлэх зорилтоос гадна өвөр монголчуудын зарим хэсгийг ажиллах хүчний хэлбэрээр нүүлгэн ирүүлэх уламжлалт бодлогыг давхар агуулж байжээ.

Түлхүүр үг: Монгол-Хятадын харилцаа, хятад ажилчид, Өвөр Монгол



Хятад ажилчдын түүхийг эргэн харах нь

Социалист интернационализмд үндэстэн гэдэг бол капитализмын үндсэн ойлголтуудын нэг бөгөөд коммунист нийгэмд хүрэх үед үндэстэн ч тэр, үндэстний төр улсууд ч тэр, тэдгээрийн хил хязгаар ч тэр устаж үгүй болно гэж үзэж байв. Монгол Улс 1990 оныг хүртэл олон арван жилийн турш гадаад харилцаандаа социалист интернационализмын зарчмыг баримталж ирсэн билээ. Үүний нэгэн жишээ нь 1955 онд БНМАУ-ын бүтээн байгуулалтад ажиллах хүчээр туслах тухай Монгол-Хятадын Засгийн газар хоорондын хэлэлцээр ба уг хэлэлцээрийн хүрээнд олон мянган хятад ажилчдыг Монголд

ажиллуулсан түүх юм. 1955-1964 оны хооронд нийт 18 мянга орчим хятад ажилчид Монголд ирж ажиллан, ХХ зууны Монголын түүхэнд томоохонд орох бүтээн байгуулалтуудыг хийж, Монголын эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулжээ. Гэвч Монголын тал тэдгээр хятад ажилчдыг анх ирүүлэхдээ амьдрах эрх олгох, гэр бүлийн хамт ирүүлэхийг эрмэлзэж байв. Энэ өгүүллээр 1950-иад онд Монголын эрх баригчид Хятадаас ажиллах хүч авахдаа ямар шалтгааны улмаас хятад ажилчдыг Монголд суурьшуулахыг эрмэлзэж байсан, энэ нь Өвөр Монголтой холбоотой эсэхийг тодруулахыг зорилоо.

Судалгааны тойм

Хятад ажилчдын тухай түүх бичлэгт үндсэн гурван чиглэл ялгаран харагдаж байна. Үүнд,

1-рт, Монгол Улсад ажиллаж байсан хятад ажилчид нь 1960-аад онд Хятадын маоизмын гар хөл болж, Монгол Улсын хууль, журмыг уландаа гишгэж, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд заналхийлэл учруулах хэмжээнд хүрээд байсан бөгөөд Ю. Цэдэнбал тэргүүтэй эх орончид эрс шийдэмгий арга хэмжээ авч хятад ажилчдыг албадан гаргасан гэж үзэх

явдал 1966 оны соёлын хувьсгалын үеэс Монголд бий болж, 1980-аад оныг хүртэл улам бүр лавширчээ.¹ Үүнд ихэвчлэн марксист үзэл суртлын үүднээс бичигдсэн судалгааны бүтээл, нийтлэл, мэдээллүүд орох бөгөөд тухайлбал, академич, түүхч Б. Ширэндэв “Хятадын удирдагчид Монголыг нэгтгэх бодлогоо тойруу замаар явуулахдаа манайд илгээсэн 12 мянган хятад ажилчдыг ашиглах зорилготой байсан” хэмээн бичсэн бол² “Монгол, Хятадын харилцааны

¹ Монгол, Хятадын харилцааны талаархи МАХН-ын интернациональч байр суурь (Өгүүллтийн эмхтгэл), Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1984 он; Далай, Ч., Шима И., Монгол-Хятадын харилцаа (1949-1980), Улаанбаатар-Прага, 1986;

² Академич Базарын Ширэндэвийн бүтээлийн чуулган, 6-р боть: Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, Улаанбаатар: 2012 он, 189-р тал.

талаархи МАХН-ын интернациональч байр суурь” бүтээлд “БНМАУ-д гэрээгээр ирж ажиллаж байсан хятад ажилчдыг тус улсын хууль дүрмийг зөрчих, үйлдвэрлэл дээр гологдол, саад, хорлол хийх хүртэл явууллагад удирдлага нь турхирах болсны улмаас янз бүрийн зөрчил гаргах явдал эрс нэмэгдсэний зэрэгцээ тэднийг улс төр-үзэл суртлын гүтгэн хорлох ажиллагаандаа өргөн ашиглаж байжээ. Энэ нь Хятадын удирдлага дахь их гүрний дээрэнгүй үзэлтэн, хятад ажилчдыг Монголд ирүүлэхдээ дотроос нь бусниулагч “тавдугаар цуваа” болгон ашиглах зорилт агуулж байсныг гэрчилнэ” хэмээн шүүмжлэн бичжээ.³ Марксист түүх бичлэгт хамаарах эдгээр бүтээлүүд хятад ажилчдын талаар голлох үйл явдлуудыг 1960-аад оны Зөвлөлт-Хятадын сөргөлдөөний өнцгөөс харж, хятад ажилчдыг буцаасан 1963 оны үйл явдлыг 1966 оны соёлын хувьсгал ба түүний дараа үед Монгол Улсын хууль, журмыг зөрчсөн хятад иргэдийг Монгол Улсаас албадан гаргасан үйл явдалтай нэг зүйл болгон бичсэн байдаг ба ялангуяа 1961 оноос эхлэн Монгол дахь хятад ажилчид ажил хаялт зарлаж, үймээн дэгдээх болсныг онцгойлон Мао Зэдунаас социалист хамтын нөхөрлөлийн эв

нэгдлийн эсрэг, Монгол Улсын тусгаар тогтнолын эсрэг явуулсан харгис бодлогын нэгэн иш баримт хэмээн авч үздэг.

2-рт, өрнөдийн голдуу судлаачид Монголд хятад ажилчид ирж ажиллах нь Монгол дахь Зөвлөлтийн нөлөө буурч, Хятадын нөлөө өсч буйг харуулах ба Монгол Улсын ажиллах хүчний хомсдолыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлсэн⁴ хэмээн үзэж байна. Гэвч өрнөдийн судлаачдын хувьд Монгол дахь хятад ажилчидтай холбогдох ихэнх баримт, эх сурвалжуудтай шууд харьцаагүйн улмаас баримт нотолгоо дутуу, ихэнхдээ (Р.Рупенээс бусад нь) ерөнхий үзэл баримтлалын шинжтэй судалгаанууддаа олон улсын харилцааны үндсэн асуудлуудын нэг болох Зөвлөлт-Хятадын харилцааны динамик өөрчлөлтөд гол анхаарлаа хандуулж байв.

3-рт, Монгол, Хятад хоёр улсын харилцаанд эерэг өөрчлөлт гарсан 1990 оноос хойш Монгол, Хятадын судлаачдын дангаараа буюу хамтран хэвлүүлсэн зохиол, бүтээлүүдэд 1950-иад онд ажиллаж байсан тэдгээр хятад ажилчид бол Монгол Улсад их хэмжээний бүтээн байгуулалтыг гардан өрнүүлж, тус хоёр улсын найрамдлын илэрхийлэл болж байсан⁵

³ *Монгол, Хятадын харилцааны талаархи МАХН-ын интернациональч байр суурь (Өгүүллийн эмтгэл)*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1984 он, 75-р тал.

⁴ Lattimore, O., *Inner Asian Frontiers of China*. Boston: Beacon Press, 1962; Lattimore, O., *Nomads and Commissars; Mongolia Revisited*. New York: Oxford University Press, 1962; Rupen, R., *The Mongols of the Twentieth Century*, Bloomington: Indiana University Publications, 1964; Rupen, R., *How Mongolia Is Really Ruled: A Political History of the Mongolian People's Republic, 1900-1978 (Histories of ruling Communist parties)*, Stanford: Hoover Institution Press, 1979; Sharad, S. K., *Mongolia-Russia Relations: Kiakhta to Vladivostok*, Delhi: Shipra Publications & Maulana Abul Kalam Azad Institute of Asian Studies, 2002

⁵ 《中蒙关系45年(1949-1994)》。内蒙古科技印刷厂印刷。1998; Бэгзжав, Л., *Монгол-Хятадын харилцаа (1949-1999 он)*, Улаанбаатар, 1999; *Найрамдал, хамтын ажиллагааны нэгэн жаран,*

хэмээн үзэх явдал зонхилж байна. Эдгээр бүтээлүүдэд Монгол Улсад хятад ажилчдын бүтээн байгуулсан олон тооны барилга, байгууламжуудын гэрэл зургийг нийтэлж, тус хоёр хөрш улсын харилцааны эерэг, сайн талыг харуулдаг ба социалист түүх бичлэг дэх үзэл баримтлалаас огт өөр шинжтэй байна.

М.Дүгэрсүрэн, Ц.Гомбосүрэн нарын “ХХ зууны Монгол Улсын гадаад бодлогын түүхэн тойм” бүтээлд ажиллах хүчний хэлэлцээрийн дагуу Монголын тал Хятадаас малчин авах хүсэлтийг гаргасан боловч Хятадын тал татгалзсан хэмээн дурьдаад, үүнийг тухайн үеийн Монгол-Хятадын харилцааны эмзэг асуудал гэж үзжээ.⁶

Д.Наранжаргалын “Хятад ажилчид БНМАУ-д (1949-1964)” бүтээлд хятад ажилчдын талаар анх удаа тусгайлан судалж, тэдний тоо, ажил мэргэжил, гэр бүлийн байдал, Монгол дахь байршил, ирсэн ба буцсан процесс, монголд үлдсэн ба нас барсан зэргийг нарийвчлан гаргажээ. Д.Наранжаргалын судалгаанаас үзэхэд, Монголд ирж ажилласан 18,300 гаруй хятад ажилчдаас Монголд ажиллаж байхдаа 89 хүн нас барж, 12 хүн гэр бүл зохиож амьдрахаар үлдсэн бөгөөд бусад нь бүгд буцжээ.⁷ Гэвч тус бүтээлд хятад ажилчдын талаар явуулсан Монголын бодлогыг зөвхөн ажиллах хүчний асуудлаар хязгаарлан

үзжээ.

Тус өгүүллийн зохиогчийн “Монгол-Хятадын социалист найрамдлын мандал, буурлын түүх: 1949-1964” бүтээлд Хятадаас ажилчин авах гэсэн Монголын хүсэлтийн цаана өвөр монголчуудыг олноор нүүлгэн ирүүлэх давхар зорилго агуулагдсан байж магадгүй тухай таамаглал дэвшүүлсэн боловч дэлгэрэнгүй авч үзэхийг зориогүй юм.⁸

Урьд өмнөх эдгээр судалгаануудын үр дүнд Монголын хүсэлтээр ирсэн хятад ажилчид Монголын бүтээн байгуулалтад үнэтэй нэмэр оруулсан нь нэгэнт тодорхой болж, Монгол-Хятадын найрамдалт харилцааны нэгэн бэлэг тэмдэг болон өнөө үед дурсагдах болов.

Гэвч хятад ажилчидтай холбогдох хоёр асуудал тодорхойгүй хэвээр байна. Үүнд, 1-рт, БНМАУ-ын зүгээс ямар зорилгоор хятад ажилчдад амьдрах эрх олгохыг хүсч байв? 2-рт, Хятад ажилчид яагаад энэ боломжийг ашиглалгүйгээр бараг тэр чигтээ БНХАУ руу буцсан бэ? Өөрөөр хэлбэл, БНМАУ-ын тухайн үеийн эрх баригчид хятадаас ажилчин авах хүсэлтийн цаана социалист интернационализмаар халхлагдсан ямар нэгэн хүн ам зүйн ба үндэстний бодлого байв уу?

Эдгээр асуудлыг МУУТА ба ГХТА-уудад хадгалагдаж буй архивын баримтууд болон БНХАУ дахь

Бээжин, 2009; *Монгол-Хятадын харилцаа жарнаас жаранд*. Улаанбаатар. 2009; 石绍湘, “中蒙关系分析(1949-1965)”, 硕士研究生论文, 外交学院, 2010; *Жоу Эньлай ба Монгол орон*, Улаанбаатар: Архивын Ерөнхий Газар, 2014;

⁶ Дүгэрсүрэн, М., Гомбосүрэн, Ц., *ХХ зууны Монгол Улсын гадаад бодлогын түүхэн тойм*, Улаанбаатар, 2004, 85-р тал.

⁷ Д.Наранжаргал, *Хятад ажилчид БНМАУ-д (1949-1964)*, Улаанбаатар, 2019, 146-147-р тал.

⁸ Н.Алтантөгс, *Монгол-Хятадын социалист найрамдлын мандал, буурлын түүх: 1949-1964*, Улаанбаатар: МУИС Пресс, 2019, 75-77-р тал.

одоогоор нээлттэй болоод буй зарим мэдээлэлд үндэслэн авч үзэхийг тус өгүүллээр зорив.

Хятад ажилчин гэдэгт “БНХАУ-аас БНМАУ-ын бүтээн байгуулалтад ажиллах хүчин илгээж туслах тухай БНХАУ-БНМАУ-ын хэлэлцээр”-ийн

дагуу 1954-1964 онуудад БНМАУ-д ирж ажилласан БНХАУ-ын иргэд ба тэдний гэр бүл 20 мянга орчим хүнийг хамруулах бөгөөд БНМАУ-д хувиараа оршин сууж байсан БНХАУ-ын иргэд ба харьяалалгүй иргэдийг хамруулаагүй болно.

Монголын санаачилга

Дэлхийн 2-р дайны дараа, ялангуяа 1950-иад онд Зөвлөлт ба Хятадаас их хэмжээний зээл, тусламж авах болсон Монголын хувьд ажиллах хүчний хомсдол тулгамдсан асуудал болов. БНМАУ 1955 оны байдлаар 831 мянган хүн амтай, түүнээс 10 хувь нь Улаанбаатар хот болон төв суурин газарт амьдарч, харин 90 хувь нь мал аж ахуй эрхлэн нүүдэллэн амьдарч байв. Төв, суурин газарт амьдарч, тогтмол орлого бүхий ажил хийдэг ажилчин, албан хаагчид 1955 оны байдлаар нийт 101.3 мянган хүн байсны дотор ажилчид 45.6 мянга байв. Ажилчдаас 18 мянган хүн аж үйлдвэрийн салбарт, 7.3 мянган хүн барилгын салбарт ажиллаж байв.⁹

1942 оны орчим МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ю. Цэдэнбал Монгол дахь ажиллах хүчний дутагдлыг хүн амын ердийн өсөлтийн замаар хангах боломжгүй талаар өврийн дэвтэртээ тэмдэглэсэн бөгөөд түүний хувийн тэмдэглэлд: “Хүн амын өсөлт нь хэрэгцээг гүйцэхгүй байна. Энэ учраас хүнтэй болгох асуудал босч ирж байгаа юм. Хэрэв бид Казахстаныг

харах юм бол хөгжиж байгаа улс ардын аж ахуй, ялангуяа аж үйлдвэрийн ажиллах хүчний хэрэгцээг зөвхөн өөрийнхөө хүн амаас мэргэжлийн ажиллах хүчнээр хангаж чадахгүй байсан биз ээ” гэжээ.¹⁰ Тэмдэглэлээс үзэхэд Ю. Цэдэнбал ажиллах хүчний дутагдлыг шийдвэрлэх арга замыг гадаадын ажилчдыг богино хугацаагаар оруулж ажил эрхлүүлэх замаар биш, харин хөдөлмөрийн насны асар олон тооны гадаадын иргэдийг ирүүлэн суурьшуулж, хүн амын тоог огцом өсгөх талаас нь харж байв.

Тэгвэл маршал Х. Чойбалсан хятадаас ажиллах хүч авах асуудлыг үндэстний агуулгаар харж байсан байж болзошгүй юм. 1945 онд Японыг Зөвлөлт-Монголын цэрэг бутцохисны дараа 1945 онд Өвөр Монголын 3,864 иргэн БНМАУ-д нүүн ирж, харьяат болсон¹¹ ба энэ нь Х.Чойбалсангийн Өвөр Монголын талаар явуулсан бодлогын үргэлжлэл байв. БНМАУ-ын Ерөнхий сайд Х.Чойбалсан 1950 оны зун дөнгөж томилогдон ирсэн Улаанбаатар дахь БНХАУ-ын анхны элчин сайд Заяатыг хүлээн

⁹ *БНМАУ-ын улс, ардын аж ахуй 1965 онд, Статистикийн эмхтгэл*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1966, 16-17-р тал.

¹⁰ *Гэрэл сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс*. Улаанбаатар. 1992, 11-р тал.

¹¹ МУУТА, ф-11, д-3, хн-409

авч уулзахдаа 300 мянган ажилчин авах хүсэлт гаргаж байсан¹² нь өвөр монголчуудыг зааж байсан бололтой. Гэвч Хятадын тал улс байгуулагдаад удаагүй хэмээх шалтгаар уг саналыг хүлээн авсангүй.

Монголын хоёр удирдагчийн үзэл санаа 1954 онд төрийн албан ёсны төлөвлөгөөнд зохих байраа олов. 1954 онд БНМАУ-ын Улсын Төлөвлөгөөний комиссоос аж үйлдвэр, барилга, тээвэр, хөдөө аж ахуйн салбарт нийт 30-35 мянган ажилчин дутагдаж байгаа хэмээн тооцоолоод үүний ихэнхийг Хятадаас ажилчин ирүүлэх замаар хангахаар төлөвлөсөн нь гадаадын ажиллах хүчийг их хэмжээгээр хэрэглэх анхны баримт болжээ.¹³

Улмаар 1954 онд БНХАУ-ын Ерөнхий сайд Жоу Энълай БНМАУ-д айлчилж, хятад ажилчдыг Монгол Улсад ажиллуулах асуудлыг зарчмын хувьд шийдвэрлэсэн бол мөн оны 11 сард БНХАУ-ын Ерөнхий сайдын орлогч Улаанхүү мөн Монголд айлчилж, МАХН-ын 12-р их хуралд оролцоходоо БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбалтай уулзаж, Хятадын тал Монголд олон тооны ажилчин илгээж туслахад бэлэн буйг илэрхийлсэн бөгөөд Ю.Цэдэнбал Хятадаас ойролцоогоор 20 мянган ажиллах хүч авахыг хүсч буйгаа хэлээд богино хугацаагаар бус, харин байнга оршин

суух зөвшөөрөлтэйгөөр ирүүлэх санал тавьжээ. Улаанхүү энэ асуудлыг шууд шийдвэрлэх боломжгүй тул тусгайлан зөвлөлдөхийг санал болгож, ингэснээр Монголд ажиллах хүч илгээх асуудлыг хоёр тал зарчмын хувьд тохиролцов.¹⁴ Улмаар мөн оны 12-р сарын 8-нд ХКН-ын Төв Хорооноос МАХН-ын Төв Хороонд илгээсэн цахилгаан утсанд “Бид танай хүсэлтэд чадахын хэрээр туслах болно” хэмээн мэдэгдэв. Ингээд нэг сарын дараа Монголын тал Улаанбаатар дахь БНХАУ-ын элчин сайдын яаманд 40 мэргэжлийн 12,250 ажилчин багаж хэрэгслийн хамт ирүүлэх хүсэлтээ гардуулжээ.¹⁵ Гэвч Хятадын Гадаад харилцааны яамнаас Элчин сайдын яамандаа илгээсэн цахилгаан утсанд “Энэ удаагийн Монголын хүссэн ажилчид мэргэжлийн хувьд хэт олон, Монголд илгээх хугацаа нэн богино, үүний сацуу холбогдох асуудлууд маш өргөн... Бүртгэх, илгээх үйл ажиллагаа маш хүндрэлтэй” хэмээн татгалзаж, улмаар Хятадын саналыг үндэслэн хоёр тал ажиллах хүчний асуудлыг нарийвчлан хэлэлцэхээр тохиров.

Эдгээрээс үзэхэд, Хятадаас ажиллах хүч авах явдал бүхэлдээ Монголын талын санал, санаачилга байсан нь тодорхой харагдана.

¹² <http://www.chinanews.com/kj/shgc/news/2006/07-29/765992.shtml> 《外交档案解密:1950年代新中国对外援助逾40亿元》，来源：新民晚报；作者：杨丽琼。2019.12.3

¹³ МУУТА, ф-11, д-2, хн-218, 204-209-р хуудас.

¹⁴ “Record of Conversation with Prime Minister of the Mongolian People's Republic, Comrade Tsedenbal. (fragments),” November 29, 1954, History and Public Policy Program Digital Archive, AVPRF: fond 0111, opis 36, папка 235, delo 3, listy 57-58. Obtained and translated by Sergey Radchenko for CWHHP. <http://digitalarchive.wilsoncenter.org/document/110479>

¹⁵ <http://www.chinanews.com/kj/shgc/news/2006/07-29/765992.shtml> 《外交档案解密:1950年代新中国对外援助逾40亿元》，来源：新民晚报；作者：杨丽琼。2019.12.3

Ажиллах хүчний хэлэлцээр дэх Монголын хүсэлтүүд

1955 оны 2-р сарын 16-нд хятад ажилчдыг ажиллуулах тухай Монгол-Хятадын хэлэлцээр Бээжин хотод эхэлжээ. Хэлэлцээр 4-р сарын 7-ныг хүртэл үргэлжилж, нийт 14 удаа хуралдсан бөгөөд ингэж олон удаа хуралдсаны шалтгаан нь Монголын талын “хачирхалтай” хүсэлтийг Хятадын тал зөвшөөрөхгүй байсантай холбоотой байв.

Монголын талын үндсэн хүсэлтүүд нь

1. Хятад ажилчдыг гэр бүлийн хамт ирүүлэх,
2. Монголд урт хугацаагаар оршин суух, таван жилээс доошгүй хугацаагаар ажиллуулах,
3. Амьдрах эрх олгох,
4. Монгол ажилчидтай ижил цалинжих,
5. Орлого цалингаа бүгдийг Монголд зарцуулах, Хятад руу гуйвуулахгүй байх зэрэг байв.¹⁶

Гадаадаас ажилчин авахдаа таван жилээс доошгүй хугацаагаар ажиллуулах, цалингаа нутагтаа гуйвуулахгүй байх, гэр бүлээ хамт авчрах зэрэг нь эдийн засгийн учир шалтгаан багатай, Монголд богино хугацаагаар ажиллах ажилчдад тохиромжгүй нөхцлүүд бөгөөд Монголд нэгмөсөн суурьшин амьдрах зорилго бүхий ажилчдын хувьд нэн таатай нөхцөл юм. Өөрөөр хэлбэл, Монголын тал Монголд нэгмөсөн суурьших бодолтой ажилчдын

сонирхохуйц тийм нөхцлийг анх санал болгож байжээ.

Харин Хятадын тал ажилчдыг анхны илгээх хугацаа нь хамгийн ихдээ 3 жил, цаашид амьдрах эрх олгох боломжтой гэж үзэж байв.¹⁷ Тус зөвлөлгөөний тухай Хятадын талын төлөөлөгчид Төрийн Зөвлөлдөө илтгэсэн тайлан дотор “Хэлэлцээний явц дунд бидний олон санал багларгдах хүртлээ бүгдийг олонтаа тайлбарлах шаардлага гарсан. Жишээлбэл, манай зүгээс ажилчдын ажиллах хугацаа гурван жил байх, Хятадаас кадр ажилчдыг илгээж, Монголд ажилчдын хэрэг эрхлэх товчоо байгуулах, ажилчид цалингийнхаа 30 хувийг ар гэртээ гуйвуулах боломжтой байх, худалдааны биш дансаар мөнгө гуйвуулах зэрэг саналыг олонтаа тайлбарлаж, санал солилцож байв” гэснээс үзэхэд Монголын тал “хятад ажилчдыг” Монголд бүрмөсөн суурьших тул Хятад руу мөнгө гуйвуулах шаардлагагүй хэмээн шаргуу зүтгэж байсан гэж үзэж болно.¹⁸ Энэ талаар олонтаа зөвлөлдсөний эцэст хоёр тал хятад ажилчид цалингийнхаа 30 хүртэл хувийг Хятад руу гуйвуулахыг зөвшөөрөхөөр тохирчээ.

“БНХАУ-аас БНМАУ-ын бүтээн байгуулалтад ажиллах хүчин илгээж туслах тухай БНХАУ-БНМАУ-ын хэлэлцээр” 1955 оны 4 сарын 7-нд батлагдсан ба дараах үндсэн тохиролцоог агуулжээ. Үүнд:

¹⁶ МУУТА, ф-8, д-3, хн-325, 148-149-р хуудас.

¹⁷ МУУТА, ф-8, д-3, хн-325, 148-149-р хуудас.

¹⁸ <http://www.chinanews.com/kj/shgc/news/2006/07-29/765992.shtml> 《外交档案解密:1950年代新中国对外援助逾40亿元》，来源：新民晚报；作者：杨丽琼。2019.12.3

1. 1955-1956 онд БНХАУ-аас ажилчин, техникч, эмч, соёлын ажилтан, орчуулагч, тогооч зэрэг 12,332 хүнийг илгээх ба үүнээс 1955 онд 8,234 хүн, 1956 онд 4,098 хүнийг Монголд ажиллахаар илгээх.
2. Хятад ажилчид Монголд гурван жил ажиллаж, хугацаа дууссаны дараа нутаг буцаж болох буюу эсхүл Монголд оршин суух эрх авч болно.
3. Хятад ажилчид Монголын хууль ба ёс журмыг хүндэтгэн дагах.
4. Хятад ажилчид интернациональч үзэлтэй, өөрийн эзэмшсэн мэргэжилдээ дадлага, туршлагатай байж, монгол ажилчидтай харилцан туршлага солилцож, харилцан сургах,
5. Хятад ажилчдыг монгол ажилчидтай ижил ажилд ижил цалин олгох, хоол ба байрыг Монголын талаас хангах, хүн бүрт өдөрт таван төгрөгийн тэтгэлэг олгох, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, нийгмийн даатгалыг үнэгүй хүртэх,
6. Хятад ажилчид Монголд ажиллах хугацаандаа сар бүр өөрийн цалингийн 30 хувиас илүүгүй мөнгийг Хятад дахь ар гэртээ гуйвуулах.¹⁹

Хэлэлцээрээс үзэхэд, олон удаа ярьж, хэлэлцсэний эцэст Монголын талын саналуудыг Хятадын тал өөрчлүүлж, Хятадын санал ихэнхдээ давамгайлсан бөгөөд 3-5 жил ажиллаад буцах ажилчдад илүү таатай нөхцлөөр хэлэлцээр байгуулагджээ. Цөөн хүн амтай Монгол Улс Хятадаас олон тооны ажилчин авчирч, тэдэнд амьдрах эрх олгохоор тохирсон энэ үйл явдал дэлхийн сонин, хэвлэлүүдийн анхаарлыг татаж, тухайлбал “Нью-Йорк Таймс” сонинд “Хятад ажилчид Монголын талтай таван жилийн хугацаатай гэрээ байгуулах бөгөөд хэрэв тэд хүсвэл Монгол Улсын иргэн болох боломжтой” хэмээн мэдээлж байв.²⁰

Өвөр Монголоос ажилчин ирүүлэх санал

Хэлэлцээр байгуулагдаж, хятад ажилчид Монголд ирсний дараа удалгүй Монголын талын жинхэнэ эрмэлзлэл ил болсон байна. Үүний анхных нь 1957 оны 2-р сарын 24-нд Монголын тал цаг уур ба амьдрах орчинд дасан зохицох шаардлагыг харгалзан үзэж 1 мянган барилгын ажилчдыг Өвөр монгол ба Зүүн

хойд мужуудаас элсүүлэн илгээхийг Хятадаас хүссэн явдал байв.²¹ Үүнд ялангуяа монгол хэл мэддэг ажилчид буюу жинхэнэ хэрэг дээрээ өвөр монголчуудыг илгээхийг Монголын тал онцлон хүссэн явдал бол Монголын тал ажиллах хүчний хэлэлцээрийг өвөр монголчуудыг олноор нүүлгэн ирүүлэх арга болгон ашиглахыг хичээж байсныг

¹⁹ 石绍湘, “中蒙关系分析 (1949-1965)”, 硕士研究生论文, 外交学院, 2010, 22页。

²⁰ Raymond, J., Mongolia Imports Chinese Workers, “New York Times”, August 28, 1956.

²¹ 石绍湘, “中蒙关系分析 (1949-1965)”, 硕士研究生论文, 外交学院, 2010, 第23页。

харуулж байна. Гэвч уг хүсэлтэд Хятадын тал тодорхойгүй шалтгаанаар татгалзжээ.

Үүнээс таван жил өнгөрсний дараа өвөр монголчуудыг ирүүлэх асуудал дээд хэмжээнд ахин сөхөгдөв. Монгол, Хятад хоёр улс Бээжин хотноо 1962 оны 12-р сард Хилийн гэрээ байгуулсны дараа Ю.Цэдэнбал, Жоу Энълай нар уулзаж ярилцсан бөгөөд уг уулзалтан дээр Ю.Цэдэнбал Жоу Энълайд хандан Монгол дахь хятад ажилчид монгол хэл, ёс заншил мэдэхгүй байгаа тул Монгол руу Хятадын өвөр Монголоос ажилчин илгээх хүсэлт тавьжээ. Тэрээр

“Манайд одоо ажиллах хүчний хэрэгцээ их байна. Танай улс хүн амаа олшруулах нь чухал гэж нөхөр Жоу Энълай та өчигдөр хэлж байсан. Ажилчдыг сайн ашиглахыг та удаа дараа зөвлөж байсныг санаж байна. Бид цаашдаа хэлэлцээрт тодорхойлсон тооноос дутагдах ажилчнаа нөхөж авах санаатай... Харин нөхөж авах ажилчны тоонд хэл мэдэхийг бодож, өвөр монголчуудаас оролцуулж өгсөн ч бид татгалзахгүй. Энэ асуудлыг бид үндсэрхэг үзэл гаргаж тавьж байгаа хэрэг биш юм. Манай Намын Төв Хороо хэдэн жилийн өмнө монголчуудыг манай улсад шилжүүлэн өгнө үү гэж танай Намын Төв Хороонд захидал бичсэн юм. Түүнд хэдэн зуун мянган монголчуудыг өгнө үү гэж дурдсан юм. Гэтэл энэ талаар тухайн

үед хариу өгөхдөө монголчуудыг шилжүүлэх боломжгүй, харин цөөн тооны хэлмэрч өгч болно гэж байсан билээ. Тийм шалтгаан байна гэдгийг бид олж хараагүй. Би дээр хэлсэн ёсоор үндсэрхэг үзэл гаргаж байгаа биш гэдгийг ойлгох болов уу гэж итгэж байна” гэжээ.²²

Ю.Цэдэнбалын үгнээс үзэхэд тэрээр гурван асуудлыг онцолсон бөгөөд 1-рт, өвөр монголчуудыг БНМАУ-д ажилчнаар илгээж туслах, 2-рт, 1957 оны өвөр монголчуудыг ирүүлэх хүсэлтэд Хятадын тал татгалзсан шалтгааныг тодруулах, 3-рт, уг асуудал үндсэрхэг үзэлтэй хамаагүй, зөвхөн “хятад ажилчдыг” бүрэн, үр дүнтэй ашиглах зорилгоор өвөр монголчуудыг илгээхийг хүсч буйгаа тайлбарласан байна. Ю.Цэдэнбал уг хүсэлтээ үндсэрхэг үзэл биш гэдгийг хоёр ч удаа давтан онцолсон явдал бол тухайн үеийн Монгол-Хятадын харилцаанд социалист интернационализм үндсэн зарчим болж байсантай холбоотой юм. Гэвч Жоу Энълай энэ саналд шууд татгалзсан бөгөөд үүнийхээ шалтгааныг МАХН ба ХКН-ын хооронд тухайн үед улам бүр өсөн нэмэгдэж байсан үзэл суртлын зөрүүтэй байдалтай холбон тайлбарлаж, харин яагаад өвөр монголчуудыг илгээхийг хүсэхгүй байгаа шалтгаанаа мөн л тодорхой илэрхийлсэнгүй.²³

²² БНМАУ-ын СнЗ-ийн дарга нөхөр Ю.Цэдэнбалд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд нөхөр Жоу Энълай бараалхаж уулзсан тухай тэмдэглэл. 1962.12.26. Бээжин.

²³ Radchenko, S., New Documents on Mongolia and the Cold War - *Cold War International History Project Bulletin*, Issue 16, pp. 356.

Хятадын бодлого

Хятад Улс БНМАУ-д ажиллах хүч илгээхдээ зөвхөн хань үндэстнийг илгээж байв. Хятад ажилчдыг Өвөр монгол, Жилин, Хармөрөн, Хөбэй, Жианси, Шанхай, Бээжин, Тяньжин, Сыжоу, Шаньдун, Халуун гол ба Шаньси зэрэг арван мужийн улсын өмчит хоршоолол болон улсын өмчит компаниудын үйлдвэрийн газруудаас элсүүлэх, хэрэв хангалтгүй байвал тухайн газрын орон нутгийн ажиллах хүчийг татан оролцуулах, газар тариаланчдыг Өвөр монгол болон заасан бусад газраас дайчилж, ингэхдээ дараах шаардлагыг тавьж байв. Үүнд:

1-рт, түүхийн мэдлэгтэй,

2-рт, бие чийрэг,

3-рт, 18-аас дээш настай,

4-рт, сайн дураараа санал гаргасан байх.²⁴

Хятадын тал Монголд илгээх ажилчдыг элсүүлэх шаардлагаа 1958 оноос өндөржүүлж, ажилчдын дунд ХКН-ын гишүүд 20-иос доошгүй хувь байх, ажилчин ба түүний гэр бүлийнхний улс төрийн статусыг улам нарийн тодорхой хөтлөх, хувьсгалын эсэргүү хэрэг болон гэмт хэргийн улмаас ял шийтгэл хүлээсэн этгээдүүд, хорлон сүйтгэх хөдөлгөөнийг удирдсан хувьсгалын эсэргүүчүүд болон бусад хорлон сүйтгэгчдийг элсүүлэхгүй байх зэрэг шалгуур тавьж эхэлжээ.²⁵

Эдгээрийн үр дүнд 1955-1964 онд Монголд ирж ажилласан БНХАУ-ын ажилчдын 99 ба түүнээс дээш хувь нь хань үндэстнээс бүрдсэн бөгөөд

Монголын талын Өвөр Монголоос ажилчин авах хүсэлтийг ор тас орхигдуулж байв. Жишээлбэл, 1959 онд илгээсэн нэг мянга орчим ажилчдын дотор Өвөр монголоос кадр 3, хэлмэрч 14, нийт 17 хүн багтсан байна.

Мао Зэдунаас Дамбад илгээсэн хятад ажилчдын тухай захидлыг Хятадын [people.com.cn](http://www.people.com.cn) цахим хуудсанд нийтэлсэн бөгөөд эндээс бид Монголд илгээх хятад ажилчдыг Өвөр Монголоос биш, харин хань үндэстнээс бүрдүүлж байсан талаарх Хятадын байр суурийг тодорхой харна. Мао Зэдун уг захидлаа МАХН-ын Төв Хорооны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Д.Дамбад хаягласан ба Монголд илгээх хятад ажилчдыг Өвөр Монголоос бүрдүүлж илгээх боломжгүйг тайлбарлаж, дараах шалтгааныг заажээ. 1-рт, ӨМӨЗО-ны оршин суугчид 8 сая гаруй боловч түүний 7 сая нь хань үндэстэн, зөвхөн 1 сая нь л монгол үндэстэн юм. 2-рт, БНМАУ-ын бүтээн байгуулалтад зөвхөн мэргэжилтэй, чадварлаг ажилтнууд шаардлагатай тул бид зөвхөн аж үйлдвэрийн ба газар тариалангийн мэргэжилтэй ажилчдыг илгээж чадна. Харин мал аж ахуйд ажиллах ажилтнуудыг илгээхэд хүндрэлтэй хэмээжээ. Тэрээр улмаар цааш нь “Хэрэв хань үндэстэн ажилтнууд танай нөхцөлд тохирохгүй, хүндрэлтэй байгаа бол бид илгээхээ цөөрүүлэх буюу илгээхгүй байж ч болох юм” хэмээн анхааруулсан байна.²⁶ Үүнээс үзэхэд, Хятадын

²⁴ 石绍湘, “中蒙关系分析 (1949-1965)”, 硕士研究生论文, 外交学院, 2010, 22页。

²⁵ 石绍湘, “中蒙关系分析 (1949-1965)”, 硕士研究生论文, 外交学院, 2010, 第24页。

²⁶ <http://www.people.com.cn/GB/shizheng/8198/30446/30452/2195989.html> 2019.12.3

тал өвөр монголчуудыг БНМАУ руу үндэстэн ажилчдыг илгээх хатуу байр илгээхээс шууд татгалзаж, зөвхөн хань суурьтай байжээ.

Монголын тал Хятад ажилчдыг Монголд суурьшуулахаас татгалзсан нь

Хятадын тал Монголд зөвхөн хань үндэстэн ажилчдыг илгээгээд зогсохгүй, хятад ажилчдыг Монголд бүрмөсөн суурьшуулахыг оролдож байв. Тухайн үед Монголд цагаач хятадууд ба хятад ажилчдыг “Хятадын харьяат нарын зөвлөл” харьяалан удирддаг байв. Монгол дахь хятадын харьяат нар нь үндсэндээ хань үндэстнээс бүрдэж байсан бөгөөд өвөр монголчуудыг Монголын эрх баригчид хань үндэстнүүдээс тусгайд нь бүртгэдэг байв. Хятадын зүгээс Монголд байгаа хятадын харьяат нарыг “БНМАУ-ын бүтээн байгуулалтад идэвхтэй оролцуулахын тулд” Монголын харьяат болгож, улмаар Хятадын харьяат нарын зөвлөл, клуб, хятад ажилчдын “Зам” сониныг мөн Монголд шилжүүлж өгөх хүсэлтэй байгаа тухай ноот бичгийг 1959 оны 3-р сарын 27-нд Монголын Гадаад Яамны орлогч сайд Лхамсүрэнд гардуулжээ. Монголын Засгийн газар уг ноот бичигт “энэ удаа зөвшөөрч чадахгүй” гэдэг хариуг өгчээ. Гэвч уг хүсэлтээ Хятадын тал удалгүй ахин дэвшүүлэв. 1959 оны 6-р сарын 23-нд Хятадын ЭСЯ-ны зөвлөх Мен Ин БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Шагдарсүрэнтэй уулзаж, Хятадын харьяат нарын зөвлөл, хятад ажилчны клуб, “Зам” сонин гурвыг Монголд шилжүүлэхийг ахин хүсчээ. Уг асуудлыг МАХН-ын Төв Хороо хянаад, зөвхөн

хятад ажилчны клуб ба хятад ажилчны “Зам” сонин хоёрыг хүлээж авахаар шийдвэрлэжээ.²⁷ Харин Хятадын харьяат нарын зөвлөлийг авсангүй, өөрөөр хэлбэл Монголын тал Хятадын харьяат нарын зөвлөлийн харьяанд байх хятад ажилчдыг Монголын иргэнээр авахаас татгалзсаар байв.

Жил орчмын дараа Хятадын ЭСЯ-ны зөвлөх Мен Ин 1960 оны 7-р сарын 26-нд ГЯЯ-ны Дорнод хэлтсийн эрхлэгч Цэрэндоржтой уулзахдаа Хятадын харьяат нарын зөвлөлийг Монголын тал гардан удирдахыг санал болгосон нь өмнөх саналаа арай өөр хэлбэрээр гурав дахь удаагаа тавьсан хэрэг байв. Уг асуудлыг ГЯЯ-ны Дорнод хэлтсийн зүгээс судлахдаа, Хятадын харьяат нарын зөвлөл гэдгийг “Монголд удтал байсан хятад иргэд” хэмээн тайлбарлаж, “тэдний ихэнх нь нэгэнт БНМАУ-ын иргэн болсон ба цөөн тооны Хятадын харьяат иргэд үлдсэн учраас тусгай зөвлөл байлгахыг үгүйсгэж байна” гэж үзжээ.²⁸ Уг тайлбарт Хятадын харьяат нарын зөвлөлд зөвхөн Монголд удтал байсан хятад иргэдийг хамруулж, харин хятад ажилчдыг багтаан үзээгүй явдал нь Монголын хувьд олон мянган хятад ажилчдыг хүлээн авахаас татгалзах арга байв.

Монголын тал анх 1955 онд “гэр бүлийн хамт аль болох удаан хугацаанд оршин суух, амьдрах эрх

²⁷ Гадаад харилцааны төв архив, х-5, д-2, хн-267, 4-р хуудас.

²⁸ Гадаад харилцааны төв архив, х-5, д-2, хн-267, 4-р хуудас.

авах” ажилчин авахыг эрмэлзэж байсан билээ. Гэвч Хятадын тал дөрвөн жилийн дараа Монголын анхны хүсэлтийнх нь дагуу олон мянган хятад ажилчдыг харьяатаар үлдээхийг хүсэхэд Монголын тал бүх аргаа хэрэглэн тэднээс татгалзжээ.

БНМАУ өөрсөддөө чухал шаардлагатай байгаа хятад ажилчдаас татгалзаж байсан боловч харин өвөр монголчуудаас татгалзаж байгаагүй нь дараах баримтаас тодорхой харагдана.

1960 онд 470 өвөр монгол иргэн, 746 харьяалалгүй иргэнийг АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар БНМАУ-ын иргэн болгосон²⁹ ба харьяалалгүй иргэдийн тухайд тэдний ихэнх нь БНХАУ-ын иргэний үнэмлэхийг аваагүй ба тэндээ бүртгэлгүй байгаад Монголд нүүн ирсэн өвөр монголчууд

байв. 1960 онд ийнхүү нэг мянга гаруй өвөр монголчууд БНМАУ-ын иргэн болсон явдал нь 1945 онд 3,864 өвөр монгол иргэнийг Монголын харьяат болгосноос хойш хамгийн өндөр тоо болсон бөгөөд өвөр монголчуудад БНМАУ-ын иргэний харьяалал олгох явдал цаашид багассан ч 1974 оныг дуустал тасралтгүй үргэлжилжээ. Монголын тал хэдийгээр хятадаас ажилчин авахдаа амьдрах эрх олгохыг эрмэлзэж байсан боловч бодит байдал дээр хятад ажилчдыг харьяатаар авах буюу амьдрах эрх олгохгүй байв. Хятад ажилчид бүхэлдээ Монголын талын хүсч байсан шиг өвөр монголчууд биш, харин хань үндэстнүүд байсан тул Монголын тал тэднийг үлдээхээс татгалзаж, зөвхөн ажиллах хүчнээр ажиллуулаад буцааж байжээ.

Дүгнэлт

(1) Монгол-Хятадын ажиллах хүчний хэлэлцээрийг байгуулах, хэрэгжүүлэх явцад баримталж байсан Монголын бодлогыг судлахад, марксист түүх бичлэгт “дайсан”, өрнөдийнхний хувьд “Зөвлөлт-Хятадын бал сарын үр дагавар”, 1990 оноос хойшхи түүх бичлэгт “Монгол-Хятадын найрамдлын бэлэг тэмдэг” болж ирсэн Монгол дахь хятадын ажиллах хүч нь мөн чанартаа Монгол, Хятад хоёр улсын үндэстний сонирхлыг агуулж байсан гэж үзэх үндэстэй байна.²⁹

(2) БНХАУ-тай 1949 онд дипломат харилцаа тогтоосны дараа Ерөнхий сайд Х.Чойбалсан өвөр монголчуудыг олноор нүүлгэн ирүүлэхийг судалж эхэлсэн бололтой бөгөөд түүний залгамжлагч Ю.Цэдэнбалын үед уг бодлогыг бодит ажил хэрэг болгохоор хятад ажилчдыг Монголд ирүүлэх хэлэлцээр байгуулжээ. 1955 оны Монгол-Хятадын ажиллах хүчний тухай хэлэлцээрт заасан хятад ажилчид Монголд амьдран суух эрх авч болох тухай заалтыг хятад ажилчдын дүрээр ирэх өвөр монголчуудад зориулжээ.

²⁹ МУУТА, х-11, д-3, хн-409.

- (3) БНМАУ-ын эрх баригчид БНХАУ-ын эрх баригчдад хандан Хятадаас авах ажилчдыг Өвөр Монголоос бүрдүүлж өгөх тухай хоёр удаа албан ёсоор хүсэлт гаргаж байсан нь өвөр монголчуудыг ажилчин хэлбэрээр нүүлгэн ирүүлэхийг эрмэлзсэн Монголын бодлогыг харуулж байна.
- (4) Хятадын тал Монгол руу ажилчнаар хань үндэстнийг илгээж, тэднийг Монголд бүрмөсөн суурьшуулахыг эрмэлзэж байсан бөгөөд харин өвөр монголчуудыг илгээхээс шууд зайлсхийж байв.
- (5) Өвөр монголчуудыг БНМАУ-д нүүлгэн ирүүлэх гэсэн БНМАУ-ын удирдагчдын бодлого Х.Чойбалсангийн үеэс эхлэн Ю.Цэдэнбал, Д.Дамба нарын хамтран эрх барьсан жилүүдэд ямар нэг байдлаар зогсолтгүй хэрэгжиж байсан бололтой.
- (6) Монголын гадаад бодлогыг Зөвлөлт улс удирдан чиглүүлж, түүний үндсэн зарчим нь социалист интернациональд суурилж байсан явдал Монголын үндэстний шинжтэй аливаа бодлогыг саармагжуулах, нууц далд хэлбэрт оруулахад хүргэж байв. БНМАУ-ын Засгийн газар өвөр монголчуудыг “хятад ажилчдын” хэлбэрээр ирүүлэх явдал нь үндэстний бодлогоо далдлах арга зам байжээ.

Эцэст нь тэмдэглэхэд, тус өгүүлэл нь БНХАУ-аас БНМАУ-д ирж ажилласан хятад ажилчдын байгуулсан гавьяа, Монголын бүтээн байгуулалтад оруулсан их хувь нэмрийг бүрхэгдүүлэхийг зориогүй. Мөн энд дурдагдсан санал, дүгнэлтүүд нь зөвхөн судлаачийн эрдэм шинжилгээний байр суурь юм.

Ном зүй:

Архивын баримт

1. МУУТА, ф-11, д-3, хн-409.
2. МУУТА, ф-11, д-2, хн-218.
3. МУУТА, ф-8, д-3, хн-325.
4. ГХТА, БНМАУ-ын СнЗ-ийн дарга нөхөр Ю.Цэдэнбалд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд нөхөр Жоу Эньлай бараалхаж уулзсан тухай тэмдэглэл. 1962.12.26. Бээжин.
5. ГХТА, х-5, д-2, хн-267.

Монгол хэлээр

1. Алтантөгс, Н., Монгол-Хятадын социалист найрамдлын мандал, буурлын түүх: 1949-1964, Улаанбаатар: МУИС Пресс, 2019.
2. БНМАУ-ын улс, ардын аж ахуй 1965 онд, Статистикийн эмхтгэл, Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1966.
3. Бэгзжав, Л., Монгол-Хятадын харилцаа (1949-1999 он), Улаанбаатар, 1999.
4. Гэрэл сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс. Улаанбаатар. 1992
5. Далай, Ч., Шима И., Монгол-Хятадын харилцаа (1949-1980), Улаанбаатар-Прага, 1986.
6. Дүгэрсүрэн, М., Гомбосүрэн, Ц., XX зууны Монгол улсын гадаад бодлогын түүхэн тойм, Улаанбаатар, 2004.
7. Монгол, Хятадын харилцааны талаархи МАХН-ын интернациональч байр суурь (Өгүүллийн эмхтгэл), Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1984 он.
8. Наранжаргал, Д., Хятад ажилчид БНМАУ-д (1949-1964), Улаанбаатар, 2019.

Гадаад хэлээр

1. Radchenko, S., New Documents on Mongolia and the Cold War - Cold War International History Project Bulletin, Issue 16
2. Rupen, R. The Mongols of the Twentieth Century, Bloomington: Indiana University Publications, 1964:
3. Sharad, S. K., Mongolia-Russia Relations: Kiakhta to Vladivostok, Delhi: Shipra Publications & Maulana Abul Kalam Azad Institute of Asian Studies, 2002.
4. 石绍湘, “中蒙关系分析(1949-1965)”, 硕士研究生论文, 外交学院, 2010
5. 《中蒙关系45年(1949-1994)》。内蒙古科技印刷厂印刷。

Цахим эх сурвалж

1. <http://www.chinanews.com/kj/shgc/news/2006/07-29/765992.shtml> 《外交档案解密:1950年代新中国对外援助逾40亿元》, 来源: 新民晚报; 作者: 杨丽琼。2019.12.3.
2. <http://digitalarchive.wilsoncenter.org/document/110479> “Record of Conversation with Prime Minister of the Mongolian People’s Republic, Comrade Tsedenbal. (fragments),” November 29, 1954, History and Public Policy Program Digital Archive, AVPRF: fond 0111, opis 36, papka 235, delo 3, listy 57-58. Obtained and translated by Sergey Radchenko for CWIHP. 2019.12.3.
3. <http://www.people.com.cn/GB/shizheng/8198/30446/30452/2195989.html> 2019.12.3

Mongolian policy of importing workers from Inner Mongolia in conjunction with the Mongolian-Chinese labor force agreement of 1954

Altantugs Namjilchoijil

Ph.D

*School of Arts and Sciences, National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia
altantugs@num.edu.mn*

Abstract: *Between 1955 and 1964, approximately 12,000 Chinese laborers were brought to Mongolia as part of an agreement between the Mongolian People's Republic and the People's Republic of China to support the construction efforts in Mongolia. In 1955, during the negotiations for this agreement, the Mongolian representatives aimed to bring in a significant number of workers and, if feasible, to grant them the right to reside in Mongolia for an extended period, as indicated in archival documents. This article aims to clarify the reasons for this request. In the process, the agreement's contents and further implementation were assessed in connection with the foreign policies and activities of Mongolia and China. The Mongolian side's desire to grant Chinese workers the right to live in Mongolia, bring their families to Mongolia, and prevent them from sending remittances to China implied their intention to allow these workers to settle permanently and eventually become Mongolian citizens. However, when the Chinese workers returned from Mongolia in 1964, there were hardly any of them who remained in Mongolia. In conjunction with certain features of Mongolia's foreign and domestic policies carried out in the 1950s, and in response to Mongolia's repeated requests to China for workers from Inner Mongolia, Mongolia's intention to acquire labor from China not only aimed to address its labor shortage but also revealed a policy of relocating some Inner Mongolians to Mongolia.*

Keyword: *Mongolian-Chinese relations, Chinese workers, Inner Mongolia*

<i>The day of submission:</i>	<i>2023.09.04</i>
<i>Completion of review:</i>	<i>2023.10.01</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2023.10.13</i>